

Өгүүлбэр ангилж сурцгаая

Алхам 1:

Асуух
өгүүлбэр

- Асуух өгүүлбэр нь асуусан утгатай. Асуух өгүүлбэрийн эцэст “?” бичнэ.

Хүүрнэх
өгүүлбэр

- Хүүрнэх өгүүлбэр нь баталсан эсвэл үгүйсгэсэн мэдээллийг агуулсан байдаг. Эцэст нь цэг тавина.

Анхааруулах
өгүүлбэр

- Анхааруулах өгүүлбэр нь анхаарал татсан утгатай. Эцэст нь анхаарлын тэмдэг бичдэг.

Захирах
өгүүлбэр

- Захирах өгүүлбэр нь захирах утга илэрхийлэх өгүүлбэр юм.

Алхам 2: Өгүүлбэр зохиож бичээрэй.

ӨГҮҮЛБЭР	ЖИШЭЭ
ХҮҮРНЭХ ӨГҮҮЛБЭР (.)	
АСУУХ ӨГҮҮЛБЭР (?)	
АНХААРУУЛАХ ӨГҮҮЛБЭР (!)	
ЗАХИРАХ ӨГҮҮЛБЭР (.)	

ЗУРГИЙГ АЖИГЛААД ТОХИРОХ ӨГҮҮЛБЭРИЙГ ЗУРАГТАЙНЬ ХОЛБООРОЙ.



Ногоон гэрлээр, цагаан гарцаар
зам хөндлөн гараарай!



Амар сайн байна уу?

Алхам 3: Анхааралтай ажиглаарай.

Доорх өгүүлбэрүүдийг зөв харгалзуулаарай

Та хэзээ ирэх вэ?

захирах

Би маргааш очно.

асуух

Хичээлээсээ хоцруузай !

хүүрнэх

Манайд хурдан ир.

анхааруулах

Доорх өгүүлбэрүүдийг гүйцээгээрэй.

А. Миний тооны дэвтрийг харсан

Б. Чиний нэр хэн

В. Сараагийнх хаашаа нүүгээ

Г. Тэртээ алсад бэлчиж буй тэмээ



Алхам 4:

4. Доорх өгүүлбэрүүдийг хувирган бичээрэй.

Чи хэдэн
настай вэ?

Асуух өгүүлбэрийг хүүрнэх
өгүүлбэр болгоорой.



Гараа сайн угаагаарай
Хүүхдүүдээ!

Анхааруулах өгүүлбэрийг
асуух өгүүлбэр болгоорой.



Би даалгавраа их
хичээнгүй сайхан
хийж сурсан.

Хүүрнэх өгүүлбэрийг захирах
өгүүлбэр болгон хувиргаарай.





Дасгал даалгавар

1. Өгүүлбэрийн төгсгөлд цэг тэмдгийг (. ! ?) бичээд зөв харгалзуулаарай.

- | | |
|--|----------------|
| ➤ Та ахмад настнаа хүндэлдэг үү | А. Анхааруулах |
| ➤ Манай нутаг ой модоор баян | Б. Захирах |
| ➤ Хоол идэхээс өмнө гараа заавал угааж бай | В. Асуух |
| ➤ Чи хичээсээ хоцруузай | Г. Хүүрнэх |

2. Дараах өгүүлбэрийг хүүрнэх өгүүлбэр болгон бичээрэй.
дэлгэрэх, өгүүлбэрийн, туяарсан

